

Мормоны Номын Төгс эзэмших сургаал: 1-р шалгалт

1 НИФАЙ 3:7-ООС МОЗАЯ 18:8-10

Төгс эзэмших сургаалын эшлэл

1–3-р асуултын хувьд, үг хэллэг тус бүрийн хажууд буй хоосон зайд холбогдох эшлэлийн үгсийг бич. Шалгалтын энэ хэсэгт судраа ашиглахгүй.

Түлхүүр үг хэллэг	Судрын эшлэл
_____ 1. “Бурханы зарлигуудыг дагадаг тэд . . . бүх зүйлд адислагдсан болой.”	a. 1 Нифай 3:7 b. 2 Нифай 2:25
_____ 2. “Би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно.”	c. 2 Нифай 2:27 d. Мозая 2:41
_____ 3. “Адам хүмүүн байж болохын тулд унасан; мөн тэд баясгалантай байж болохын тул хүмүүн байх бөлгөө.”	e. Мозая 3:19

Судрын түлхүүр үг хэллэг

4–6-р асуултын хувьд, төгс эзэмших сургаалын судрын түлхүүр үг хэллэгийн дутуу орхисон үгсийг нөхөж бич. Шалгалтын энэ хэсэгт судраа бүү ашигла.

4. “Та нар _____ байгаа нь та нар зөвхөн _____
үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тулд буюу” (Мозая 2:17).
5. “ _____ хүмүүнээ [орхиж] мөн Их Эзэн Христийн _____
_____ [болж]” (Мозая 3:19).
6. “ _____ байгуулснаа _____, Их Эзэний нэрээр _____
хүртгэхэд юу нь та нарт болохгүй байх билээ” (Мозая 18:8–10).

Бодит амьдрал дээрх нөхцөл байдалд хэрэгжүүлэх

Та шалгалтын үлдсэн хэсэгт судруудаа ашиглаж болно.

7–8-р асуултын хувьд, дараах нөхцөл байдалд орсон хүнд туслах төгс эзэмших сургаалын судрын нэг эсвэл хэд хэдэн хэсгийг тодорхойлж, судрын үнэн хэрхэн тусалж болох талаар тайлбарла. Дараа нь 9-р асуултын зааврыг дага.

7. Нэгэн залуу эрэгтэй өөрийнх нь ирээдүйд ихээхэн нөлөөлж болохуйц чухал шийдвэр гаргах хэрэгтэй байгаа. Тэрээр сандарч мөн ямар сонголт хийхээ мэдэхгүй байв.

8. Нэгэн залуу эмэгтэй Бурханы зарлигуудыг дагахад маш хэцүү амьдралын нөхцөл байдалд амьдардаг. Тэрээр дуулгавартай байхыг хүсдэг ч энэ нь түүний нөхцөл байдалд ахадмаар хүнд санагддаг.

9. 1 Нифайгаас Мозая хүртэлх төгс эзэмших сургаалын 12 хэсгээс аль нэгийг сонгоод, тухайн хэсэгт заасан үнэнүүд өсвөр насны хүүхдийн амьдралд тусалж болох нөхцөл байдлыг хуваалц.

Сүнслэг мэдлэг олж авах зарчмууд

10–11-р асуултын хувьд, сүнслэг мэдлэг олж авах зарчмуудыг ашиглах мэдлэг, чадвараа харуул.

10. Сүнслэг мэдлэг олж авах дараах гурван зарчмыг өөрийн үгээр товч тайлбарла.

a. Итгэлээр үйлд.

b. Утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.

c. Тэнгэрээс томилогдсон эх сурвалжуудаар дамжуулан илүү гүн гүнзгий ойлголт олж авахыг эрэлхийл.

11. Нэгэн найз маань сургуульд заасан зарим зүйл яагаад сударт болон өнөөгийн бошиглогчдоор дамжуулан заасан Бурханы сургаалуудтай зөрчилдөж байгааг асуув. Дараах асуултуудад хариул.

a. Тэрээр итгэлээр үйлдэхийн тулд юу хийж болох вэ?

b. Энэ байдлыг мөнхийн талаас харах нь түүнд хэрхэн тусалж болох вэ?

- с. Төгс эзэмших сургаалын судрын хэсгүүд бол тэнгэрээс томилогдсон эх сурвалжийн нэгэн жишээ юм. Төгс эзэмших сургаалын 1 Нифайгаас Мозая хүртэлх аль хэсэг таны найзад тус болж болох вэ? Яаж?

Таны амьдралд үзүүлэх нөлөө

12. Энэ улирлаар судалсан төгс эзэмших сургаалын судрын хэсгээс аль нь танд хамгийн их нөлөөлсөн бэ? Энэ нь танд хэрхэн нөлөөлсөн бэ? Судрын уг хэсэг танд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын талаар юу зааж байна вэ?
